



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/662

Хэрлэн сум


Хэрлэн сумын Дөрөвдүгээр цэцэрлэгт
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16 дугаар зүйлийн 16.5.5, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.16 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэрлэн сумын дөрөвдүгээр цэцэрлэгийн сантехникийн шугам сүлжээ цоорсон гэмтэл Мэргэжлийн хяналтын газрын 2011 оны 1 дүгээр сарын 18-ны №04/06/49/26 дугаартай дүгнэлтээр тогтоогдсон тул засварын ажилд зориулж, 2,203,234 (хоёр сая хоёр зуун гурван мянга хоёр зуун гучин дөрөв) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардлагатай хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж эвдрэх тохиолдолд хохирлыг арилгах зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ